

**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР” БОЛОН ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ПРОТОКОЛЫН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 4 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3.1 дэх заалтад заасны дагуу хэлэлцээрийн төслийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо тус тус хуралдаанаараа урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн болно.

Хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төсөл байгуулагдсанаар Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хамтын ажиллагаа газрын тосны салбарт өргөжиж, агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой үнээр нийлүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийсэн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалт хийсний үр дүнд авах хүү болон хэлэлцээрийн зарим зүйл, заалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл газрын тосны бүтээгдэхүүний үнэ тогтмол өсөж байгаа энэ үед Засгийн газар хоорондын хэлэлцээр батлагдах нь ямар давуу тал, ач холбогдолтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат олон улсын өнөөгийн нөхцөл байдалд хэлэлцээр хийж байгаа нь эрсдэлтэй эсэх, агаарын хөлгийн түлш, болон бусад газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр цаашид олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахдаа баримтлах үндсэн бодлого, зарчмыг тодорхойлох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд газрын тос, нефтитэй холбоотой хэлэлцээр хамаарах нь зохимжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга “Чингис хаан” олон улсын нисэх буудлаас бусад хилийн боомтууд дээрх хэлэлцээрийн үйлчлэлд хамаарах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, олон улсын гэрээ, хэлэлцээрийн төслийг агуулга, ач холбогдол, түвшнээр нь эрэмбэлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар олон улсын гэрээ, хэлэлцээрт нэр томъёог зөв, тодорхой хэрэглэх, хэлэлцээрийн зүйл, заалтыг тодорхой, ойлгомжтой болгосноор улс хоорондын найрсаг харилцаанд

эрсдэл үүсгэхээс сэргийлэх тул цаашид анхаарах талаар, Улсын Их Хурлын Ж.Энхбаяр агаарын тээвэр эрс өсөж байгаа өнөө үед газрын тосны нийлүүлэлт, бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Байнгын хорооны хуралдаанаар олон улсын гэрээ, хэлэлцээрийг иргэдэд нээлттэй хэлэлцэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Монгол Улс нефть боловсруулах үйлдвэрээ барих, үнийн өсөлтөд анхаарч ажиллах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Байнгын хороодын гишүүдийн гаргасан саналыг анхаарч гэрээнд гарын үсэг зурах, гэрээг соёрхон батлахаар ирүүлэхдээ зөвшилцөхөд гарсан саналуудыг тусгасан эсэх талаар танилцуулж байх талаар үг хэллээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН